**САНГИЙН ЯАМНЫ**
**ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2020 оны 05 сарын 04 өдөр | Дугаар А69 | Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн яамны төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий Ёс зүйн зөвлөлийг яамны албан хаагчдын санал асуулгын дүнгээр хамгийн олон санал авсан дараах албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ёс зүйн зөвлөлийн дарга:

| | |
|---|---|
| Д.Дэгд | Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга: |

Гишүүд:

| | |
|---|---|
| В.Рэнцэнханд | Төрийн сангийн газрын Төлбөр, тооцооны хэлтсийн дарга; |
| Б.Болормаа | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын ахлах шинжээч; |
| Ж.Ганбаяр | Эдийн засгийн бодлогын газрын Макро эдийн засгийн бодлогын хэлтсийн шинжээч; |
| Д.Соёлмаа | Төсвийн хөрөнгө оруулалтын газрын ахлах мэргэжилтэн; |
| К.Гүлжан | Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн; |

Нарийн бичгийн дарга:

| | |
|---|---|
| Э.Номин-Эрдэнэ | Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн. |

9766 00325

2. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллахыг Ёс зүйн зөвлөл /Д.Дэгд/-д даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.НАРАНЦОГТ